



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА,
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР**

2024 оны 12 сар

**Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн
чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**
(2024 оны жилийн эцсийн байдлаар, Эрүүл мэндийн яам)

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” батлагдсан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Хүний хөгжлийн бодлогын “Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” Зорилго 2-ын “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ” Зорилт 2.2, “Эрүүл, баталгаат орчныг бий болгоно” Зорилт 2.5, Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ” Зорилт 2.7, “Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” Зорилго 8-ын “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ” Зорилт 8.3, “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” Зорилго 9-ын “Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ” Зорилт 9.1-ийн хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар нийт 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2024 онд эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээ хүлээгдэж буй үр дүндээ хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээг хийж, журмын дөрөвдүгээр хавсралт ёсоор тайланг нэгтгэн гаргасан. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын 6.2.2, 6.2.3 дугаар заалтад заагдсан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх аргачлалыг баримтлан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар тооцон гаргасан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 13 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 62.3 хувьтай үнэлэгдсэн.

“Тодорхой үр дүнд хүрсэн” 2 (15.4 хувь) арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.2.6. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ (СТГ);

2. 2.7.2. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ (ЭТБГ).

“Тодорхой үр дүнд хүрсэн” 6 (46.1 хувь) арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ (НЭМБГ);

2. 2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна (НЭМБГ);

3. 2.2.4. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ (ЭТБГ, СЭЗБГ);

4. 2.2.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ (СТГ);

5. 2.2.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна (ТЗУГ);

6. 8.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ (СХГ).

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн хэрэгжилттэй 3 (23.1 хувь) арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.2.3. Оношлогоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ (ЭТБГ);

2. 2.2.5. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна (СТГ, СЭЗБГ, ТЗУГ);

3. 2.5.4. Эрүүл мэнд болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлнэ (НЭМБГ).

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилттэй 2 (15.4 хувь) арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.7.4. Хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно (СТГ, НЭМБГ);

2. 9.1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана (СТГ).

Шалгуур үзүүлэлтийн биелэлтийн талаар

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 11 шалгуур үзүүлэлтийг баталсан. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 30.8 хувь байна.

Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан хувь шалгуур үзүүлэлтийг тусгайлсан судалгаагаар гаргах тул үнэлгээнд хамруулаагүй болно.

10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн буюу 100.0 хувийн үнэлгээтэй байна.

“Үр дүнгүй” буюу 0 хувийн үнэлгээтэй дараах 4 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

- Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь;
- Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь;
- Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь;
- Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь зэрэг болно.

Таван жилийн үндсэн чиглэлийг 2024 онд хэрэгжүүлэхэд нийт 1,879.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Үүнд:

- 2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ - дархлаажуулалтад 17.1 тэрбум төгрөг (улсын төсөв);

- 2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна - 27.3 тэрбум төгрөгийг (Эрүүл мэндийн даатгалын сан);

- 2.2.3. Оношлогоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ - 2.3 тэрбум төгрөг (Эрүүл мэндийг дэмжих сан, Эрүүл мэндийн даатгалын сан);

- 2.2.4. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ - 49.4 тэрбум төгрөгийг (улсын төсөв, Польш Улсын Засгийн газар, Дэлхийн банк);

- 2.2.5. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж,

иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна - 1,809.5 тэрбум төгрөг (Эрүүл мэндийн даатгалын сан);

2.2.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ - 607.0 сая төгрөг (улсын төсөв) зэрэг болно.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 13 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 62.3 хувь, шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 30.8 хувьтай байна.

2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт 1,879.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Тав. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан эрүүл мэндийн салбарын арга хэмжээнээс 2024 оны жилийн эцсийн үнэлгээгээр 70-аас доош хувийн үнэлгээтэй 5 арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

2. Таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан эрүүл мэндийн салбарын арга хэмжээг яам, газар, хэлтсийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, хэрэгжүүлэх;

3. Газар, хэлтсийн дарга нар Таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;

4. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнаж байх.

Эрүүл мэндийн яам
2024 оны 12 дугаар сар